



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2004 оны 4 сарын 21 өдөр

Дугаар 180

Улаанбаатар хот

Иргэдэд үйлчлэх “Буян компани” НӨҮГ-ыг
татан буулгаж, Нийслэлийн өмчийн
оролцоотой “Улаанбаатарбуян” ХХК-ийг
байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 2 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 48 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Иргэдэд үйлчлэх “Буян компани” нийслэлийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг зохион байгуулах комиссыг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Иргэдэд үйлчлэх “Буян” нийслэлийн өмчит үйлдвэрийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан авлага, өр төлбөрийг байгууллага хүмүүстэй тооцоо нийлсэн дүнгээр барагдуулж, байгууллагын хаалтын балансыг 2004 оны 5 дугаар сарын 10-ны дотор гаргаж, холбогдох байгууллагад тушаахыг Татан буулгах комисс /Ж.Эрдэнэбаатар/-т даалгасугай.

Гурав. Шинээр өөрчлөгдөн байгуулагдаж буй “Улаанбаатарбуян” ХХК-ний 34 хувийг нийслэлийн өмчийн, 66 хувийг “Нью Майнд” ХХК-ний хөрөнгийн оролцоотой байхаар хамтарсан компани байгуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т даалгасугай.

Дөрөв. “Улаанбаатарбуян” ХХК-д шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.

Тав. Дээрх захирамжийн биелэлтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/-т даалгасугай



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2004 оны
4-р дүгээр сарын 21-ны өдрийн
180-дугаар захирамжийн хавсралт

Иргэдэд үйлчлэх “Буян” нийслэлийн өмчит
үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг
зохион байгуулах комисс

Комиссын
дарга

Ж.Эрдэнэбаатар

- Нийслэлийн Өмчийн харилцааны
газрын хэлтсийн дарга

Гишүүдэд

Я.Одгэрэл

- Нийслэлийн Өмчийн харилцааны
газрын мэргэжилтэн

Б.Саруул

- Нийслэлийн Өмчийн харилцааны
газрын мэргэжилтэн

Б.Бүрэнцэцэг

- Нийслэлийн Өмчийн харилцааны
газрын мэргэжилтэн

Р.Ягаанцэцэг

- НЗДТГ-ын Нийгмийн бодлогын
хэлтсийн эрүүл мэндийн салбар
хариуцсан мэргэжилтэн